

Байгууллагын түүх

Монгол улсын Засгийн газрын тогтоолоор 1990 онд “Нийслэлийн санхүүгийн хэлтэс”-ийг “Санхүүгийн газар” болгон өргөжүүлж түүний бүрэлдэхүүнд “Татварын тасаг”-ийг ажиллуулжээ. Монгол улсын Засгийн газрын 1992 оны 17 дугаар тогтоол, түүнийг үндэслэсэн Нийслэлийн засаг дарга, Улсын албан татварын Ерөнхий газрын даргын 1992 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн б/217/5 дугаар хамтарсан захирамж, тушаалаар Улаанбаатар хотын “Албан татварын алба”-ыг, орлогын болон хяналт шалгалтын хэлтэс, мэдээллийн, тээвэр хяналтын тасагтайгаар, дүүргүүдийн албан татварын хэлтсийг улсын үйлдвэрийн газрын орлогын тасаг, хоршоо хувиараа эрхлэх аж ахуйн орлогын тасаг, бүртгэл мэдээллийн хэсэгтэй байхаар тогтоожээ.

Монгол улсын засгийн газрын 1992 оны 25 дугаар тогтоолоор нийслэлийн Засаг даргын дэргэд “Татварын алба” байгуулсантай холбогдуулан Улаанбаатар хотын Засаг даргын 1992 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн б/216 дугаар захирамжаар Я.Аюушжав, Т.Тэрбиш, Ч.Поотой, Х.Төмөрбаатар, О.Замбага, Х.Сүрэнхүү, Ц.Уранчимэг, Л.Бадамцэцэг, Ц.Цэцэгмаа, С.Өтебай, Ц.Ишдорж, С.Туул, О.Сэр-Од нарыг 1992 оны 10 дугаар сарын 1-ээр тасалбар болгон санхүүгийн газрын татварын байцаагчийн үүрэгт ажлаас чөлөөлж, мөн өдрөөс нийслэлийн Засаг даргын дэргэдэх Татварын албаны мэдэлд шилжүүлж энэхүү захирамжаар Онгоодой овогтой Сэр-Одыг 1992 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс Нийслэлийн Засаг даргын дэргэдэх татварын албаны даргаар томилжээ.

1992 онд Монгол улсын татварын багц хуулиудыг батлан гаргаж, 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлснээр татварын одоогийн тогтолцооны эх үүсвэр тавигдсан байна.

Нийслэлийн Татварын алба нь 1992 оноос эхлэн Нийслэлийн төвийн 6 дүүрэг, Багануур, Багахангай, Налайх, Жаргалант, Гачуурт, Туул дүүргүүдийн татварын хэлтсүүд, нийслэлийн Татварын газраас бүрдэж, байсан бөгөөд 1993 онд 385 байцаагч ажиллаж байв.

Нийслэлийн Татварын албаны дүүргүүдийн татварын хэлтсийн анхны дарга нар:

- 1.Сүхбаатар дүүрэг Я.Баттогтох
2. Чингэлтэй дүүрэг Б.Чүлтэмсүрэн
- 3.Баянгол дүүрэг О.Чимэд

- 4.Баянзүрх дүүрэг Д.Пүрэвсүрэн
- 5.Хан-Уул дүүрэг Т.Очирбат
- 6.Сонгино хайрхан дүүрэг Ч.Санжхүү
7. Багануур дүүрэг Д.Оюунцэцэг
- 8.Налайх дүүрэг Б.Сайн-Амгалан
9. Багахангай дүүрэг Д.Цэрэндаш
10. Жаргалант дүүрэг Н.Цэвэлсүрэн
11. Гачуурт дүүрэг Б.Гүррагчаа
12. Туул дүүрэг Г.Халзай

Нийслэлийн Татварын газарт 1994 оны 01 дүгээр сарын 02-ноос Хэрэг бүртгэх тасаг шинээр байгуулагдсан бөгөөд 1995 оны УИХ-ын 16, Засгийн газрын 23, Нийслэлийн Иргэдийн Тэргүүлэгчдийн Хурлын 13 дугаар тогтоолоор Гачуурт, Жаргалант, Туул дүүргүүд татан буугдаж, тосгоны зохион байгуулалтад орсон тул дээрх 3 дүүргийн татварын хэлтсийг 1995 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс татан буулгаж байцаагчдыг нь Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн татварын хэлтсүүдэд шилжүүлсэн байна.

Нийслэлийн татварын газрын бүтэц зохион байгуулалт

1992 онд /анхны бүтэц/

- 1.Газрын /татварын албаны/ дарга
- 2.Орлогын хэлтэс
- 3.Хяналт шалгалтын хэлтэс
- 4.Бүртгэл мэдээллийн хэлтэс
- 5.Тээврийн хяналтын хэлтэс

1994 онд

- 1.Газрын дарга
- 2 Татвар хураалт, үйлчилгээний хэлтэс
- 3.Шалган байцаах хэлтэс
- 4.Мэдээлэл боловсруулалтын хэлтэс
- 5.Боловсон хүчин, дотоод хяналтын тасаг
- 6.Тээврийн хяналтын тасаг
- 7.Хэрэг бүртгэх тасаг

1997 онд

- 1.Газрын дарга
2. Дэд дарга
- 3.Хяналт шалгалтын хэлтэс
- 4.Татвар хураалт үйлчилгээний хэлтэс
- 5.Мэдээлэл боловсруулалт, статистикийн хэлтэс
- 6.Боловсон хүчин захиргааны хэлтэс

2000 онд

- 1.Газрын дарга
- 2.Дэд дарга
- 3.Татвар ногдуулалтын хэлтэс
- 4.Татвар хураалтын хэлтэс
- 5.Мэдээлэл боловсруулалт статистикийн хэлтэс
- 6.Хянан байцаах хэлтэс /хяналт шалгалтын болон хэрэг бүртгэх тасагтай/
- 7.Удирдлага нөөцийн хэлтэс зэрэг бүтэцтэй байсан байна.

Нийслэлийн Татварын газрын даргаар ажиллаж байсан хүмүүс:

- | | |
|------------------|-------------------------|
| 1. О.Сэр-Од | 1992.10.01 - 1996.09.07 |
| 2. Ч.Ганболд | 1996.09.07 - 2000.01.21 |
| 3. Х.Төмөрбаатар | 2000.01.21 - 2000.09.07 |
| 4. С.Энхбаатар | 2000.09.07 - 2013.03.14 |

Нийслэлийн Татварын газар нь 2001 онд Үндэсний Татварын ерөнхий газрын хэмжээнд оны ажлаараа 1 дүгээр байранд орж, мөнгөн шагналаар шагнуулсан бол 2003 онд 3 дугаар байранд орж байсан байна.

Байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилго:

Нийслэлийн Татварын алба нь Монгол Улсын Татварын Ерөнхий хууль, татварын салбар хуулиуд, тэдгээрийн биелэлтийг хангахтай холбогдсон хууль эрхийн актуудын хэрэгжилтийг нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих, нийслэлийн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэхэд чиглүүлэн нийслэл, дүүргүүдийн татварын албадын ажлыг нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор байгуулагдсан байна. Дараах үндсэн зорилгуудыг хэрэгжүүлж иржээ.

Өмчийн олон хэлбэр зэрэгцэн оршиж, татвар хураах ажлын үүрэг цар хүрээ, ач холбогдол нэмэгдэхийн хирээр татварын албаны бүтэц, зохион байгуулалтанд өөрчлөлт орж, мэргэжлийн боловсон хүчнээр хангах талаар цөөн жилийн дотор багагүй зүйл хийсэн байна. Жишээ нь.: Сүүлийн жилүүдэд татварын албаны бүтэц, удирдлага зохион байгуулалт, арга зүйг боловсронгуй болгон үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор Нийслэлийн Татварын албаны бүтцийг өөрчлөн зохион байгуулж хэлтэс тасгийн тоог нэмэгдүүлсэн ба энэ нь татвар төлөгчдөд татварын хууль тогтоомжийг сурталчлан заавар зөвөлгөө өгч, гарын авлагаар хангах, тайлан тэнцлээ хуулийн хугацаанд нь татварын албанд тушааж орлого, татвараа үнэн зөв тодорхойлдог арга барилд сургах мөн Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналтыг хүчтэй болгоход чиглэгдсэн байна. Цаашилбал дүүргүүдийн татварын хэлтсүүдэд тусгай тасаг шинээр байгуулснаар татвар төлөхөөс зайлсхийсэн, тайлан тэнцлээ хугацаанд нь тушаагаагүй, татварын тооцоо хийгдэггүй аж ахуй нэгж, татвар төлөгчийг эрэн сурвалжилж олох, татварын эцсийн тооцоо хийлгэж захиргааны хариуцлага хүлээлгэх, татвараа санаатайгаар нууж дарагдуулах, татвар төлөхөөс зайлсхийсэн, татварын албаны шаардлага биелүүлээгүй үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй бол хэрэг бүртгэлд хийж эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалтанд шилжүүлэх, татвар төлөгчийн ажлын байр, агуулах сав, шаардлагатай объектод нэвтрэн орж үзлэг, нэгжлэг хийх, хөрөнгийг битүүмжлэх, татвар төлөгчдийг албадан саатуулах зэргээр хуулийн хүч, механизмыг ашиглах эрх үүрэгтэйгээр ажилладаг байна.

Мөн дараах зорилтуудыг тавьж ажиллаж иржээ

Аж ахуй нэгж, байгууллага бүртэй жигд ажиллаж нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, тэтгэвэр тэтгэмж, санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгох, зах зээлийн эдийн засгийн нөхцөлд төрийн анхаарал халамж зайлшгүй шаардах, иргэдийг нийгмийн халамжийн талаар тусгагдсан зорилтууд болон нийгмийн хамгааллын тухай хуулиудад орж байгаа өөрчлөлтийг хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын тооцооллын багц программ хангамжийг бүх дүүрэгт туршиж эхлэх, өр авлага барагдуулах зэрэг нь тухайн албаны хамт олны үндсэн зорилтуудтай ажилладаг байна.

Хоёр. Хөмрөгийн баримтын түүх

1990 онд Нийслэлийн санхүүгийн хэлтсийг санхүүгийн газар болгон өргөжүүлж бүрэлдэхүүнд нь Татварын тасгийг ажиллуулж байгаад Монгол улсын засгийн газрын 1992 оны 17 дугаар тогтоолыг үндэслэн Нийслэлийн Засаг даргын,

Улсын албан татварын ерөнхий газрын даргын 1992 оны б/217/5 дугаарын хамтарсан захирамж, тушаалаар Улаанбаатар хотын албан татварын албыг, орлогын болон хяналт шалгалтын хэлтэс, мэдээллийн, тээвэр хяналтын тасагтайгаар зохион байгуулагдсанаас хойш төрийн архиваар баримт бичгээ нэг ч удаа цэгцлүүлээгүй бөгөөд өөрсдөө баримт бичигтээ ЭШТБ-н ажлыг хийж иржээ.

2001 онд Нийслэлийн Архивын албаны ажилтнуудаар баримт бичигтээ эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийлгэсэн байна. Үүнд: 1990 онд байнга хадгалах баримт огт байхгүй, 1991-1993 оны баримт бичиг маш бүрдэл дутуу зөвхөн 1991 оны Тээврийн татвар хяналтын товчооны даргын тушаал, 1992, 1993 оны Тээврийн хяналтын товчооны болон Албан татварын албаны даргын тушаал л хадгалагдан бүртгэгджээ.

1994 онд Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Татварын газар болон өөрчлөгдсөн ба 1994-1996 он хүртэлх баримт нь Газрын даргын тушаал, Зөвлөлийн хурлын протокол, жилийн ажлын төлөвлөгөө тайлангаас бусад байнга хадгалах баримт хадгалагдан үлдээгүй байна. Харин 1997-1999 онуудад Маргаан таслах зөвлөлийн тогтоол шинээр нэмэгдэж байнга хадгалах баримтад хадгалагдан үлдсэн байна.

Нийслэлийн Архивын албаны ажилтан Л.Долгор, Ц.Ганцэцэг нар тус байгууллагын баримт бичигт эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг хийхдээ Төрийн архивт шилжүүлэх 1991-2000 оны 31 хадгаламжийн нэгж бүхий байнга, байгууллага өөр дээрээ хадгалах 1993-1999 оны 17 хадгаламжийн нэгж бүхий байнгын 2 бүртгэл данс, 1992-2000 оны 435 хадгаламжийн нэгж бүхий түр хадгалах баримтын бүртгэлийг үйлджээ.

2002 онд тус байгууллага нь архивын өрөөгөө тохижуулан, архивын зориулалттай тавиурууд хийлгэж зориулалтын тавиур шүүгээн дээр хадгалах болсон байна.

2000 он болон түүнээс өмнөх онуудын архивт өгөөгүй материалыг хүлээн авч хадгаламжийн нэгж бүрдүүлэн бүртгэлд авснаар түр хадгалах хадгаламжийн нэгж 1 ба 2-р данс нийт 939 ХН, байгууллага дээр байнга хадгалах хадгаламжийн нэгж нийт 26 ХН болсон байна. Хадгалах хугацаа дууссан түр хадгалах 20 хадгаламжийн нэгжийг бүртгэлээс хассанаар түр хадгалах 919 ширхэг хадгаламжийн нэгжтэй болжээ. Эдгээр баримтуудаас бусад нь хадгалагдаж ирээгүй байна. Өөрөөр хэлбэл тухайн үеийн хэлтэс тасгуудын үйл ажиллагаатай холбоотой баримт хадгаламжийн нэгж ирээгүй байна.

Одоогоор тус байгууллага дээр хадгалагдаж байгаа баримтуудыг дурьдвал:

Түр хадгалах баримт нь 2 данстай хадгалагдаж байгаа бөгөөд 1-р дансанд үнэт цаасны тооцоо, тайлан баланс, цалингийн баримт, ААНБ-ын баримт материалууд, жилийн хагас жилийн дэлгэрэнгүй мэдээ, дансны баримтууд, харилцсан бичиг, хяналт шалгалтын акт, банкны хуулга, өрийн үлдэгдлийн судалгаа, татвар хураалтын мэдээ, ААНБ-ын судалгааны илтгэх хуудас, татварын төлөвлөгөө, НӨАТ худалдан авалтын падан зэрэг нэр төрлийн 1997-2000 оны 723 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Мөн 2-р дансанд дээрх төрлөөс гадна 2001-2003 оны татвар төлөлтийн гэрчилгээ, төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн мэдээ, кассын машинтай холбоотой баримт зэрэг 383 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Архивт хадгалагдаж байгаа 2003 оноос хойшхи баримт материал нь нэгдсэн бүртгэлд ороогүй байна. Байгууллага дээр хадгалагдаж байгаа байнга хадгалах баримтуудыг дурьдвал: 2001 оноос хойшхи газрын даргын тушаал, зөвлөгөөний хурлын тэмдэглэл, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь, байнга хадгалах шаардлагатай гэж үзсэн ирсэн явсан бичиг зэрэг 2000-2004 оны 39 хадгаламжийн нэгжийг нэгдсэн бүртгэлд оруулсан байна. Баримтын бүртгэлээс харахад 2001 оноос хойшхи баримтууд мөн бүрдэл маш дутуу байгаа ба байгууллагын жилийн ажлын төлөвлөгөө тайлан, ажилтнуудын үр дүнгийн гэрээ, төлөвлөгөөний биелэлт болон үндсэн үйл ажиллагаатай холбоотой бусад баримт бичгүүд болно.

Тус байгууллага нь Нийслэлийн архивт 2001 оны 04 сард хөмрөг үүсгэсэн байх бөгөөд дээр дурьдсанаар 1991-2000 оны байнга хадгалах 31 хадгаламжийн нэгжийг шилжүүлсэн тус архивын дэргэдэх БНШАЗК-н хурлаар данс бүртгэлийг батлуулсан байна. Улаанбаатар хотын Тээврийн татвар хяналтын товчооны даргын тушаал, /1991-1992 онд/, Албан татварын албаны даргын тушаал /1992/, Тээврийн татварын хяналтын товчооны даргын тушаал /1993/ зэрэг баримтууд хадгалагдаж байгаа бөгөөд эдгээр онуудад тушаалаас өөр баримт материал хадгалагдаагүй байна. 1994 оноос Татварын газрын даргын тушаал 1994-2000 он хүртэл бүрэн бүрдэлтэйгээр хадгалагдаж байгаа бөгөөд зөвлөлийн хурлын тэмдэглэл, байгууллагын үйл ажиллагааны тайлан төлөвлөгөөнүүд хадгалагдан ирсэн байна.

Төрийн архив баримт хадгалах хугацаанд 2001 онд сан хөмрөгийн эрхлэгч Ц. Ганцэцэг, 2002 онд архивч Ч. Цэцэгмаа, 2004 онд мэргэжилтэн Ц. Рэгзэдмаа нар тооллогын ажлыг хийж байсан ба 2004 оноос өмнө бүрэн тоологдож байсан

байна. Харин 2004 оны тооллогоор 3 хадгаламжийн нэгж дутуу тоологдсон байна. Эдгээр баримтыг олж авах арга хэмжээг зохион байгуулсан ба байгууллага дээр ашиглагдаж байгаа болно.

Дахин боловсруулалтын ажлын явцад баримтын данс бүртгэл нэгжүүдтэй зөрсөн, байнга болон түр хадгалах баримтууд холилдсон, хуудасны тоо хэтэрсэн зэрэг зөрчлүүдийг арилгаж, техник боловсруулалтын ажил хийсэн болно. Үүнд:

Байнга хадгалах баримтад дээд газрын тогтоол шийдвэр, 2002-2011 оны газрын даргын тушаал, хурлын тэмдэглэл, жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, татварын орлогын төлөвлөгөө түүний биелэлт, жилийн эцсийн санхүүгийн тайлан зэрэг баримтууд, 2003-2011 оны Татварын ерөнхий газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлт, 2003, 2005, 2008 онуудын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт зэрэг багтаасан болно.

Тус газарт ирсэн дээд газрын захирамжлалын баримтанд нягтлан шалгалт хийж байгууллагын архивт байнга хадгалах хадгаламжийн нэгжийг бүртгэлд авсан.

70 жил хадгалах баримтын бүрдлийн хувьд 1997 оны цалингийн тооцооны хүснэгтэд 10-12 сар, 1998 оны 7-12 сар, 2001 оны 7-12 сар, 2004 оны 1-3 сар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тооцооны хуудаснаас 1997 оны 10-12 сар, 1998 оны 7-12 сар, 4-12 сар, 2003 оны 4-6 сар, 2-3 сарын баримтууд дутуу байна.

Нийслэлийн Татварын газрын даргын тушаал /хүний нөөцийн холбогдолтой/, ажилтан, албан хаагчдыг шагналын тодорхойлолт, анкет зэрэг хадгаламжийн нэгж бүрдүүлсэн.

Баримтыг цэгцлэх явцад:

-Нийслэлийн архивын газар, мэргэжлийн хүмүүстэй байнгын ажил төрлийн холбоотой заавар, зөвлөлгөөний дор ажилласан. Манай байгууллагыг хариуцсан Нийслэлийн архивын газрын зааварлагч, арга зүйч Н.Цацралтуяа ажлын байранд ирж үзэж, зааварласан.

-Нийслэл Татварын газар татварын салбарын үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтыг батлуулаад мөрдлөгө болгон ажиллаж байна.

-Нийслэл, дүүргүүдийн татварын архивчидтай 2013 оны 10 сарын 14-нд хуралдаж протокол хөтөлсөн.

- ББНШК-ын хурлыг хуралдуулж, протокол хөтөлсөн.

Газрын даргын тушаалуудыг үдсэн хадгаламжийн нэгжид нооргууд холилдсон байсныг ялган авч устгал хийсэн.

- 2002-2011 оны Газрын даргын тушаалуудыг хүний нөөц, үйл ажиллагааны холбогдолтойг нь тусад нь салган нэгж болгосон.

- Жилийн ажлын төлөвлөгөө, тайланг сар, улирлынхаас ялган авсан

- Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийн баримтыг хэд хэдэн онуудыг нэгтгэн нэгж бүрдүүлсэн байсныг салгаж жил, жилээр нь нэгж болгон төрөлжүүлсэн

- Шуурхай хурал болон даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлүүд холилдсон байсныг салгаж ангилсан

- Харилцахын баримтаас цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тайлангуудыг ялган авсан.

ЭШТБ-ын ажлын үр дүнд:

- 2001-2011 оны 116 хадгаламжийн нэгж бүхий байнга хадгалах данс,
- 2005-2011 оны 1331 хадгаламжийн нэгж бүхий түрийн бүртгэл,
- 1992-2011 оны 53 хадгаламжийн нэгжийн 70 жилийн бүртгэл,
- 1992-2008 оны эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдолгүй гэж үзсэн 17 нэр төрлийн 2953 хадгаламжийн нэгжийг устгах устгах хэргийн актыг тус тус үйлдэв.